

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ
ӨДӨР/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-8
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-24
	1.Батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга танилцуулах	13-15
	2.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	15-18
	3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	18-20
	4.Цахим гарын үсгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	20-24

ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, шинжээч Х.Сүрэнхорол, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Цагдаагийн Ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Мэдээллийн холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал У.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт Б.Золбоо, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг” гэснийг “биометрик мэдээллийг” гэж өөрчилж, 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасаж, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Улсын Их Хурлын гишүүнийг хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор биометрик мэдээллийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	16
Бүгд:	44

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.11 дэх заалтын “мэдээллийн эзний” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх гэсэн саналаар санал хураалт явуулаагүй болно.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж өөрчилж, мөн зүйлийн “цахилгаан шат” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	17
Бүгд:	46

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах

1.Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.харилцаа холбоо, цахим сүлжээ ашиглаж;

2.2.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Эрх бүхий албан тушаалтан” гэснийг “Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, бусдад дамжуулсан, эсхүл эрх бүхий албан тушаалтан” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 22

Бүгд: 46

52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны хамтарсан танилцуулгыг Улсын Их хурлын гишүүн Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ням-Осорын Учрал танилцуулна.

Индэрт урьж байна, таныг.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын болон Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороод 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан санал болон хуралдаан даргалагчаас төслийн зарим зохицуулалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгснийг баримтлан Улсын Их Хурлын гишүүнийг хуралдааны ирцэд бүртгэх, санал хураалт явуулахад биометрик мэдээллийг ашиглах, түүнчлэн хүний хувийн мэдээллийг задруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, ялын бодлогыг ялгамжтай оногдуулах зорилгоор хувь хүний нууцыг задруулсан, харилцаа холбоо, цахим сүлжээг ашигласан бол зургаан сараас таван жил хүртэл хорих ял оногдуулдаг байх саналыг тус тус боловсруулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-т заасны дагуу санал хураалгасан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд хуулийн төсөлд заасан шилжилтийн үеийн зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг Гүйцэтгэх ажлын тухай хуулийг баримтлан хүний эрхийг зөрчиж болохгүй бөгөөд хууль бусаар дуу-дүрсний бичлэг үйлдсэн, худалдан борлуулсан тохиолдолд оногдуулах хариуцлагыг чангатгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат

мэдээлэл хариуцагч мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, алдсан тохиолдолд оногдуулах хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хууль хяналтын байгууллагаас санал авсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Доржханд цаг үеийн асуудлаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Ажлын хэсгийг танилцуулъя.

Болор-эрдэнэ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Ган-Эрдэнэ мөн яамны Мэдээллийн технологийн газрын дарга, Билэгдэмбэрэл Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга, Тэнгис Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга, Нямдаваа Цагдаагийн Ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Тамир Мэдээллийн холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал, Сүрэнхорол Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Амгалан мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн гэсэн ажлын хэсгийг танилцуулж байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байвал нэрээ өгье. Ганбат гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Ганбат асуулт асууна.

Д.Ганбат: Ерөнхийдөө Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль ингээд дараалаад орж ирж байна л даа. Эцсийн хэлэлцүүлэг нь явж байна. Энэ 2 хуулийг бол ерөнхийдөө дэмжиж байна. Үүнтэй холбогдуулаад бас хэд хэдэн тодруулах ч юм уу үг хэлэх шаардлага байна аа. Мэдээлэл бол ил тод байх ёстой. Гэхдээ хүний хувийн мэдээлэл бас тодорхой хэмжээнд нууцлагдаж байх ёстой.

Би юу хэлэх гээд байна вэ гэхээр саяхан Ардын намын хурал болж байна аа. Азид анх удаа байгуулагдсан нам гэж байна аа. Тэгээд 100 жил болсон юм байна аа. Бас тэгээд улс төрийн ууган хүчин гэж байгаа. Манай Монгол Улсдаа. Тэгэхэд одоо Өмнөд Солонгост манай 13 настай эмэгтэй хүүхэд 6 цаг зодуулсан байгаа юм. 7 сарын 01-нд. Гэтэл тэр мэдээлэл Солонгосын сонин дээр гарснаар л ил болж байгаа юм. Ийм л байдалтай байгаа юм. Тэгээд би энэ засаг, төр барьж байгаа, энэ 100 жил болсон намын өмнөөс бол уул нь хурлаа хийсэнд нь дарга цэргээ сонгосонд нь баяр хүргэмээр байгаа юм л даа. Гэхдээ Монгол Улсын иргэний хувьд би ичиж байна аа. Ийм 100 жил болсон намтай, Өмнөд Солонгосоос жишээ авмаар байгаа. Өмнөд Солонгос маань 30, 40 жилийн өмнө л ардчилсан

замыг сонгосон. Ингээд сонгоод явахдаа бол эхлээд их олон иргэд гадаадад ажилладаг байсан. Ялангуяа тэр Германд их олуулаа очиж ажиллаж байсан. Тэнд маш хүнд нөхцөлд ажиллаж байхад нь бол Солонгос Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нь очоод тэр ард иргэд дээрээ та нарыг ийм хүнд хэцүү нөхцөлд ажиллаж, амьдруулж байгаадаа үнэхээр уучлал гуйж байна аа. Би 20-хон, 30-хан жилийн дараа энэ улс орныг яг энэ улс орон шиг болгоно оо гээд яриад амлаж байсан. Яг түүндээ хүрсэн. Солонгос Улс бол.

Гэтэл 100 жил болчихоод ийм байгаа юм. Тэгээд Азид хамгийн анхны нам гээд цээжээ дэлдээд байдаг. Тэгсэн мөртөө ард түмний амьдрал аягүй хүнд байна. Тэр 13 настай хүүхдийн ээж бол уйлан дуугараад хэлж байгаа байхгүй юу. Би тэр өнөөдөр Солонгос Улсад суугаа Элчин сайдын яаманд би харьцаагүй ээ. Харьцах ч үгүй ээ. Тэр Элчин сайдын яамны ажилтнууд ямар байдаг, тэр Элчин сайд нь яаж томилогддог, ямаршуухан маягаар ажилладгийг нь мэддэг учраас би итгэхгүй байсан юм. Итгэлгүй хандсан гэж байгаа юм. Ийм нөхцөлд тэр Солонгос Улсад ажиллаж байгаа Элчин сайдын яамныхаа нөхөдтэйгөө яаж хариуцлага тооцоод байгаа юм.

Тийм юм ерөөсөө ярихгүй байж байж л тэр хувь хүний эрх, эрх чөлөө, мэдээлэл, тэгээд авлигатай тэмцэнэ гээд аман дээрээ л яриад байх юм. Ард түмэн чинь зовж зүдэрч байна шүү дээ. Та нараас ичиж байна, зовж байна. Тэгээд л их сайхан юм яриад байдаг. Тэд 13 настай хүүхэд яаж зовж байна. Түүний өмнөөс хэн ч юу ч ярихгүй, уучлал гуйхгүй байна шүү дээ.

Ингэж болох юм уу, нөхөд өө. Энэ дээрээ арга хэмжээ авах ёстой. Тэр Солонгос Улсын Элчин сайдын яамны тэр сайдтай нь хариуцлага тооц. Үтэр түргэн. Эсвэл Гадаад хэргийнхээ сайдтайгаа хариуцлага тооц. Эсвэл энэ Засгийн газар гарч ирээд хариуцлагаа ярь. Тэр Өмнөд Солонгост очиж тэр ард иргэдийнхээ амьдралтай танилц. Ер нь ирэх 7 хоногийн 1 дэх өдөр хилийн гадна үнэхээр хүнд нөхцөлд ажиллаж амьдарч байгаа та нарын буруугаас болж, ийм хэцүү нөхцөлд амьдарч байгаа ард иргэдийнхээ хүний эрхийн талаар тэр Гадаад хэргийн яамнаас би асууя гэж бодож байна. Ардчилсан намын бүлэг энэ талаар авч хэлэлцье гэж бодож байна. Ингэж л хариуцлага ярихгүй бол тэр Авлигатай тэмцэх газрын чуулган ямар одоо юутай байна аа. Хамгийн үнэтэй зочид буудалд баахан авлигачид юм уу, дарга нар цугларчихсан яриад л байдаг.

Т.Аюурсайхан: Үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1. Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг” гэснийг “биометрик мэдээллийг” гэж өөрчилж, 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2

дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасаж, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Улсын Их Хурлын гишүүнийг хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор биометрик мэдээллийг.”. Санал гаргасан Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороо.

Төхөөрөмжийн ажиллагааг шалгаж санал хураалт явуулъя. Гишүүд ээ.

Гишүүд байраа эзлээрэй.

Төхөөрөмжийн бэлэн байдлыг техникийн хэлтсийнхэн хангахыг хүсье.

Техникийн санал хураалт дахин явуулъя.

Төхөөрөмж ажиллагаагүй гишүүн байна уу.

Томьёоллыг танилцуулсан. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

63,6 хувийн саналаар дэмжигдлээ.

2 дугаар асуудал. Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал. Үүнд Улсын Их Хурлын Тамгын газраас тайлбар хэлж байгаа. Анхны хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын даргын зүгээс хуулийн зүйл заалт, бусад хуультай нийцүүлэх, нягтлах ийм чиглэлийг өгсөн. Үүнийг нь Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд дэмжээгүй байна аа. Эрхэм гишүүд ээ. Энэ бол анхны хэлэлцүүлэг биш эцсийн хэлэлцүүлэг. Тийм учраас энэ дэмжээгүй, чиглэл өгсөн дээр дэмжээгүй саналыг ингэж чуулган дээр эцсийн хэлэлцүүлэг дээр санал хураах боломжгүй юм байна аа гэсэн ийм чиглэлийг өгч байна.

Дараагийн асуудалдаа оръё.